

ОРЛОГО БАГАТАЙ ОРНУУДАД АВЛИГ ХҮН ТӨРӨЛХТӨНД ГАМШИГ УЧР

– Бизнесийн компаниудын дуулиант хэргүүдийг багасгахын тулд хөгж

Берлин. 2008 оны есдүгээр сарын 23. Сомали, Ирак зэрэг авлигын түвшин хамгийн өндөр байгаа орнуудын жишээнээс харахад ядуурал нь хээл хахууль, бэлэг үйлчилгээ хэтрүүлэн авах гэмт хэрэг болон зохих ёсоор ажиллаж чадахгүй байгаа төрийн байгууллагын үйл ажиллагаатай шууд хамааралтай болохыг энэ өдөр толилуулж буй Транспэрэнси Интернэшнлийн (ТИ) Авлигын түвшин тогтоох индекс 2008 (АТТИ) харуулж байна. Мөн зарим чинээлэг хөгжингүй оронд хяналтын механизмын хүчин чадал эрс суларсныг 2008 оны АТТИ-д дурджээ.

"Ядуу буурай орнуудад эмнэлгийн үйлчилгээ авах болон цэвэр усны төлөө хууль бусаар мөнгө төлөх явдал газар авч, авлига нь үхэл амьдралын хоорондох ялгааг улам ихэсгэж байна" гэж ТИ-ийн тэргүүн, хатагтай Хюгетт Лабелль онцлон тэмдэглэжээ. "Олон оронд нүүрлээд байгаа ядуурал, авлигын түвшин өндөр байгаа зэрэг нь хүн төрөлхтөнд гамшиг учруулсаар байгаа бөгөөд үүнийг цаашид тэвчих аргагүй болжээ. Түүнчлэн байдал арай дээр эгдэх орны хувьд авлигатай тэмцэх талаар өмнөхөөсөө илүү нарийн арга барилаар хандах шаардлагатай болж байна."

2008 ОНЫ ҮР ДҮН

ТИ-ийн АТТИ-ийн судалгаанд хамрагдсан тухайн орны төрийн албан дахь авлигын түвшинг бизнесийн хэд хэдэн судалгаа болон нарийн мэргэжилтнүүдийн дүгнэлтэд тулгуурлан, тэдгээрийн үр дүнг нэгтгэсний үндсэн дээр гаргадаг юм. АТТИ нь 2008 онд, 2007 оныхтой адил, нийт 180 орны авлигын түвшинг тогтоосон бөгөөд судалгаанд хамрагдсан улс орнуудад 0-10 хүртэл оноо ногдуулж байр эзлүүлсэн байгаа. "0" нь авлигын мэдрэгдэх түвшин дээгүүр байна гэсэн үзүүлэлт бол, "10" нь авлигын мэдрэгдэх түвшин дор байгааг

харуулна.

Авлигын мэдрэгдэх түвшний жагсаалтыг Дани, Шинэ Зеланд, Швед зэрэг улс 9.3, Сингапур 9.2 оноогоор тэргүүлж байхад, Ирак, Мианмар улс 1.3, Гаити улс 1.4, Сомали улс 1.0 гэсэн үзүүлэлтээр хамгийн сүүлд оржээ. Хэдийгээр энэ оны АТТИ-г өмнөх оныхтой харьцуулахад дээрх үзүүлэлтүүд огцом өөрчлөгдөөгүй мэт харагдах боловч бодит байдал дээр зарим оронд багагүй өөрчлөлт гарсан байна. Тухайлбал 2007 оны болон 2008 оны судалгаанаас харахад Болгар, Бурунди, Малдив, Норвеги, Их Британи улсын хувьд үзүүлэлт буурсан байна.

Үүнтэй адилаар, өнгөрсөн жилийн хувьд Албани, Кипр, Гүрж, Мауришус, Нигери, Оман, Катар, Өмнөд Солонгос, Тонга болон Турк улсын хувьд тодорхой ахиц гарсан байна.

ХЯНАЛТ БА ХАРИУЦЛАГЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ НЬ

Орлого их ба бага орнуудад авлигатай тэмцэхийн тулд олон нийтийн болон төрийн байгууллагын үр дүн бүхий үйл ажиллагаа, хүчин чармайлт их чухал байдаг. Ядуу буурай орнуудад ихэнхдээ шүүхийн тогтолцоо нь авлигад идэгдсэн, парламентын хяналт үр нөлөөгөө алдсан байдаг. Нөгөө талаар, чинээлэг орнуудын хувьд гадаад оронд хээл хахууль үйлдэж буй өөрийн хувийн хэвшлийнхний үйл ажиллагаанд хүрч үйлчлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байхын зэрэгцээ санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага болон гэрээ хэлцэлд тавих хяналт сул байдаг.

Хатагтай Лабеллийн хэлснээр "Авлигыг таслан

Авлигын төвшин тогтоох индекс-2008

№	Улс орон	АИ*	№	Улс орон	АИ*	№	Улс орон
1	Дани	9,3	61	Намиби	4,5	121	Непал
1	Шинэ Зеланд	9,3	62	Хорват	4,4	121	Нигер
1	Швед улс	9,3	62	Самоа	4,4	121	Сао Том ба Принсип
4	Сингапур	9,2	62	Тунис	4,4	121	Того
5	Финлянд	9,0	65	Куб	4,3	121	Вьетнам
5	Швейцар	9,0	65	Кувейт	4,3	126	Эрирей
7	Исланд	8,9	67	Эль Салвадор	3,9	126	Эфиоп
7	Нидерланд	8,9	67	Гүрж улс	3,9	126	Гаяна
9	Австрали	8,7	67	Гана	3,9	126	Гондурас
9	Канад	8,7	70	Колумб	3,8	126	Индонез
11	Люксембург	8,3	70	Румын	3,8	126	Ливи
12	Австри	8,1	72	Болгар	3,6	126	Мозамбик
12	Хон Конг	8,1	72	БНХАУ	3,6	126	Уганд
14	ХБНГУ	7,9	72	Македон	3,6	134	Коморын арлууд
14	Норвеги	7,9	72	Мексик	3,6	134	Никарагуа
16	Ирланд	7,7	72	Перу	3,6	134	Пакистан
16	Их Британи	7,7	72	Суринам	3,6	134	Украин
18	Бельги	7,3	72	Свазиленд	3,6	138	Либер
18	Япон	7,3	72	Тринидад ба Тобаго	3,6	138	Парагавай
18	АНУ	7,3	80	Бразил	3,5	138	Тонга
21	Санта Лючия	7,1	80	Буркина Фасо	3,5	141	Камерун
22	Барбадос	7,0	80	Морокко	3,5	141	Иран
23	Чили	6,9	80	Саудын Араб	3,5	141	Филиппин улс
23	Франц	6,9	80	Тайланд	3,5	141	Йемен
23	Уругвай	6,9	85	Албани	3,4	145	Казахстан
26	Словени	6,7	85	Энэтхэг	3,4	145	Тимор-Лесте
27	Эстони	6,6	85	Мадагаскар	3,4	147	Бангладеш
28	Катар	6,5	85	Монтенегро	3,4	147	Кени
28	Сант Винсент ба Гренадин	6,5	85	Панам	3,4	147	ОХУ
28	Испани	6,5	85	Сенегал	3,4	147	Сири
31	Кипр	6,4	85	Серб	3,4	151	Беларус
32	Португал	6,1	92	Алжир	3,2	151	Т7в Африкийн БНУ
33	Доминик	6,0	92	Босни Герцеговин	3,2	151	Кот ди Вуар
33	Израиль	6,0	92	Лесото	3,2	151	Эквадор
35	Арабын Нэгдсэн Эмират	5,9	92	Шри Ланка	3,2	151	Лаос
36	Ботсван	5,8	96	Бенин	3,1	151	Пагуа Шинэ Гвиней
36	Мальт	5,8	96	Габон	3,1	151	Тажикстан
36	Пуэрто Рико	5,8	96	Гватемаль	3,1	158	Ангол
39	Тайвань	5,7	96	Ямайка	3,1	158	Азербайжан
40	?мнд Солонгос	5,6	96	Кирибати	3,1	158	Бурунди
41	Мауришус	5,5	96	Мали	3,1	158	Конго БНУ
41	Оман	5,5	102	Боливи	3,0	158	Гамби
43	Бахрэйн	5,4	102	Джибути	3,0	158	Гвиней Биссау
43	Макао	5,4	102	Доминикан БНУ	3,0	158	Сьера Леон
45	Бутан	5,2	102	Ливан	3,0	158	Венесуэль
45	Чех улс	5,2	102	Монгол	3,0	166	Кампучи
47	Кейп Верде	5,1	102	Руанд	3,0	166	Киргиз
47	Коста Рик	5,1	102	Танзани	3,0	166	Туркмени
47	Унгар	5,1	109	Аргентин	2,9	166	Узбек
47	Йордан	5,1	109	Армян улс	2,9	166	Зимбабве
47	Малайз	5,1	109	Белизе	2,9	171	Ардчилсан Конго
52	Латви	5,0	109	Молдов	2,9	171	Экваторын Гвиней
52	Словак	5,0	109	Соломоны арлууд	2,9	173	Чад
54	?мнд Африк	4,9	109	Вануату	2,9	173	Гвиней
55	Итали	4,8	115	Египт	2,8	173	Судан
55	Сейшель	4,8	115	Малави	2,8	176	Афган
57	Грек	4,7	115	Малдивын арлууд	2,8	177	Гаити
58	Литв	4,6	115	Мавритани	2,8	178	Ирак
58	Польш улс	4,6	115	Нигер	2,8	178	Мианмар
58	Турк улс	4,6	115	Замби	2,8	180	Сомали

